

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11 дэх заалт болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсэг, 112.2.13 дахь заалтыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “НДҮЗ” гэх/ 2021 оны үйл ажиллагааны тайлангаа 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр албан бичгээр Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо болон Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийсэн бөгөөд дараах асуудлыг хамруулан гүйцэтгэсэн болно.

1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь хуулиар олгосон чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар;
2. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хурал, Засгийн газраас үүрэг, чиглэл болгосон тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар;
3. Байгууллагын үйл ажиллагаандаа системчилсэн үнэлгээ хийсэн эсэх талаар зэрэг болно.

Нэг.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь хуулиар олгосон чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар:

НДҮЗ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан 9 бүрэн эрх, Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан НДҮЗ-ийн дүрэмд заасан 11 эрх, 8 үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд дараах 9 бүрэн эрхийг тодорхойлсон. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, тэтгэвэр нэмэгдүүлэх талаар санал боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;
2. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих;
3. Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, боловсон хүчний хангалт, санхүүгийн асуудлаар нийгмийн даатгалын байгууллагын тайлан мэдээллийг сонсон хэлэлцэж, санал дүгнэлт гаргаж, энэ талаар холбогдох арга хэмжээ авах;
4. Нийгмийн даатгалын байгууллагын цахим тооцоолуурын техник, технологи, программ хангамж, үйлчилгээний байдлыг хянаж үнэлэлт дүгнэлт өгөх;

5. Нийгмийн даатгалын төв байгууллагын бүтцийг батлах, нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих;
6. Нийгмийн даатгалын асуудлаар журам, зөвлөмж гаргах;
7. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс болон гомдлын шаардлагын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар түүнд хяналт тавих;
8. Нийгмийн даатгал, эмнэлэг хөдөлмөрийн магадлагааны асуудлаар иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг барагдуулах;
9. Хууль тогтоомжид заасан бусад тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлэх зэрэг 9 бүрэн эрхийг хуулиар олгосон.

Харин Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэмд хуулиар олгосон дээрх 9 бүрэн эрхээс гадна хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах 3 эрх, 3 үүргийг хэрэгжүүлж ажиллахыг заасан байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй Засгийн газар, ажил олгогч, даатгуулагч, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж чиглэл өгөх;
2. Нийгмийн даатгалын сангуудын талаар мэдээ, тайлан, судалгааг Засгийн газар, ажил олгогч, даатгуулагч, нийгмийн даатгалын байгууллагаас гаргуулан авах;
3. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад хийх шалгалтад Мэргэжлийн хяналтын болон аудитын байгууллагыг оролцуулах;
4. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд Засгийн газар, ажил олгогч, даатгуулагч, иргэд, олон нийтийн байгууллагын идэвхтэй оролцоог хангуулах;
5. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардагдах арга хэмжээ авах;
6. Үнэ, ханш, амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг өөрчлөлттэй холбоотой саналыг хянан үзэж, дүгнэлт гаргах зэрэг болно.

НДҮЗ 2021 оны үйл ажиллагааны тайлангаа ирүүлэхдээ хуулиар олгосон дээрх 9 бүрэн эрхээс дараах 5 бүрэн эрхийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайлагнасан байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тухай хууль тогоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих;
2. Нийгмийн даатгалын байгууллагын цахим тооцоолуурын техник, технологи, программ хангамж, үйлчилгээний байдлыг хянах;
3. Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлд нь хяналт тавих;
4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар хяналт тавих;
5. Нийгмийн даатгал, эмнэлэг хөдөлмөрийн магадлагааны асуудлаар иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг барагдуулах гэсэн 5 чиг үүргийн хэрэгжилтийг тайлагнаж ирүүлсэн байна.

1.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих, нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлж дараах үр дүнтэй ажилласан байна. Үүнд:


Нийгмийн даатгалын сан (цаашид “НДС” гэх)-ийн 2021 оны төсвийн тухай хуульд 2,398.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас НДС-ийн орлогын гүйцэтгэл

2,732.0 тэрбум төгрөг болж өссөн нь шимтгэлийн орлого 118.5 хувиар өссөнтэй холбоотой байна.

НДС-ийн чөлөөт мөнгөн хөрөнгийг арилжааны банканд хадгалуулж хүүгийн орлого олоогүй, “КОВИД-19” цар тахлын үед эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нийгмийн даатгалтай холбоотой алданги, торгууль ногдуулаагүйтэй холбоотойгоор бусад орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7 дахин буурсан байна. “КОВИД-19” цар тахлын улмаас өвчлөлийн тоо нэмэгдсэнтэй холбоотой тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.9 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар нэмэгдсэн байна.

Харин НДС-ийн нийт зарлага 2,594.3 тэрбум төгрөг байхаар баталснаас тус сангийн зарлагын гүйцэтгэл 2,565.5 тэрбум төгрөг байна.

Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны орлого, зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөгөөр)



2021 оны байдлаар НДС-аас олгож буй бүрэн тэтгэврийн доод хэмжээ 350.0 мянган төгрөг байгаа нь амьжиргааны доод түвшингээс 46.6 хувиар илүү, 2021 онд улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 1.5 хувиар өссөн¹ гэж НДҮЗ-ийн тайланд дүгнэсэн байна.

1.2 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын байгууллагын цахим тооцоолуурын техник, технологи, программ хангамж, үйлчилгээний байдлыг хянаж, үнэлэлт дүгнэлт өгөх хуулиар олгосон эрхийн хүрээнд дараах томоохон ажлыг гүйцэтгэсэн байна. Тухайлбал,

- Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах ажлыг өргөжүүлэх, даатгуулагчдад чирэгдэлгүй шуурхай үйлчлэх зорилтын хүрээнд нийгмийн даатгалын болон тэтгэврийн дэвтрийг цахим хэлбэрт шилжүүлж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан 982.2 мянга, сайн дураар даатгуулсан 155.4 мянга, нийтдээ 1137.7 мянган даатгуулагчид QR код бүхий нийгмийн даатгалын цахим дэвтэр, шинээр тэтгэвэр тогтоолгосон 32.7 мянган хүнд тэтгэвэр авагчийн цахим дэвтрийг олгосон байна.
- Нийгмийн даатгалын салбарт хэрэглэгдэж байгаа нийт 30 төрлийн анхан шатны маягтыг бүрэн цахимжуулсан, төрийн 16 байгууллагатай төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан мэдээллийг тогтмол солилцдог болсон байна.
- Нийгмийн даатгалын гар утасны аппликейшныг 207.2 мянган иргэн идэвхтэй хэрэглэдэг, төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаас 4 төрлийн лавлагаа тодорхойлолтыг 130.5 мянган иргэн авсан бол нийгмийн даатгалын цахим системээр дамжуулан 151.4 мянган

¹ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээний тайлан

ажил олгогч, давхардсан тоогоор 1.7 сая даатгуулагч шимтгэл төлөлтийн QR код бүхий тодорхойлолтоо үүсгэн ашигласан байна.

1.3 Эмнэлэг хөдөлмөрийн магадлал

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс үйл ажиллагааг боловсронгуй болгох магадлагааны асуудлаар иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг барагдуулах, хяналт тавихад чиглэсэн хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд хийсэн ажлыг дараах байдлаар тайлагнаж ирүүлсэн байна.

“Даатгуулагчид хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон байдалд хяналт, шалгалт хийх аян”-ыг зохион байгуулж, нийт 63,341 даатгуулагч хамрагдсанаас 3,742 зөрчил илрүүлэн, 997 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалснаар жилд 4.2 тэрбум төгрөгийг хэмнэсэн үр дүнг үзүүлсэн байна. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийг шинэчлэн баталсан байна.

НДҮЗ нь 2021 оны үйл ажиллагааны тайланг ирүүлэхдээ нийгмийн даатгалын хамрагдалт, сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах, хяналт шалгалт, лавлах үйлчилгээ гэсэн нийгмийн даатгалын салбарт авч хэрэгжүүлсэн бусад арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж ирүүлсэн байна.

Харин тэтгэвэр нэмэгдүүлэх талаар санал боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, боловсон хүчний хангалт, санхүүгийн асуудлаар нийгмийн даатгалын байгууллагын тайлан мэдээллийг сонсон хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж, энэ талаар холбогдох арга хэмжээ авах зэрэг хуулиар олгосон чиг үүргийн хэрэгжилтийг тайлагнаж ирүүлээгүй байна.

Хоёр.Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хурал, Засгийн газраас үүрэг, чиглэл өгсөн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

НДҮЗ нь 2021 онд нийгмийн даатгалын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн нийгмийн даатгалын салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж, дэлхий нийтийг хамарсан “КОВИД-19” цар тахлын үед ажил олгогч, даатгуулагчдын санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор Улсын Их Хурлаас баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажилласан байна.

2.1 Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн талаар

Нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох хүрээнд 2021 онд Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн барьжээ. Эдгээр хуулийн төслүүдэд тусгагдсан онцлох өөрчлөлтүүдээс дурдвал:

- **Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд** Нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, хуримтлагдсан орлогыг өвлүүлэх зохицуулалтуудыг тус тус тусгаж, НДС-ийн хөрөнгийн удирдлагад шинэчлэлт хийх, эрсдлийн үнэлгээний мэргэшсэн хороо,

ажилтнуудтай байх, сангийн удирдлагад аюулгүй найдвартай байлгах, төлбөр түргэн төлөгдөх, хөрвөх чадвартай байлгах, үр ашиг, өгөөжтэй байх олон улсын жишигт нийцсэн зарчмаар удирдан зохицуулж, НДС-нд үүсээд байгаа өрийн асуудлыг дахин давтахгүй, гаргахгүй байхаар боловсруулсан;

- **Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд** олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настан бүрт суурь тэтгэвэр олгох, иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах, тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлэх, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих асуудлуудыг тусгасан;
- **Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд** ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсан, ихэр хүүхэд төрүүлсэн эхийн амаржсаны тэтгэмжийн хэмжээг тус тус нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг ОУХБ-ын стандартад нийцүүлэх, ажил олгогчид 3 жилд нэг удаа 15 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхээр зохицуулсан;
- **Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд** урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн протез, ортопедын үнийг 3 жил тутамд 1 удаа бүтэн чөлөөлөх, үйлдвэрлэлийн осол гаргаагүй ажил олгогчид 15 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, үйлчилгээг цахимжуулах асуудлууд тусгагдсан;
- **Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд** Монгол Улсад анх удаа хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, ахмад настнууд ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, хангалттай орлогын эх үүсвэртэй байх боломжийг олгохоор тусгасан талаар тайланд дурдсан байна.

Улсын Их Хурлаас 2020 онд “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд А/34 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг хэрэгжүүлэх заавар” болон 11 төрлийн түр маягтын загварыг шинэчлэн баталсан байна. Мөн “Ковид-19” цар тахлын үед аж ахуйн нэгж, даатгуулагчдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх ажлыг үргэлжлүүлж 38.9 мянган ажил олгогч, 410.7 мянган албан журмын даатгуулагч, 169.2 мянган сайн дурын даатгуулагчдад нийтдээ 873.9 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна. Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас 7.3 мянган ажил олгогчийн давхардсан тоогоор 80.9 мянган даатгуулагчид 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлжээ.

2021 онд иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу тэтгэврийн зээлгүй болон 1 сая хүртэлх төгрөгийн тэтгэврийн зээлтэй тэтгэвэр авагч 229277 иргэнд 207.5 тэрбум, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нас барж, үнэт цаасыг ар гэрийн хүнд нь өвлүүлсэн 5043 иргэнд 4.7 тэрбум, нийт 234320 иргэнд 212.2 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Улсын Их Хурлаас 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч, даатгуулагч 9.5 байсныг 8.5 хувь,

сайн дураар даатгуулагч 12.5 байсныг 11.5 хувь болгож тус бүр нэг хувиар бууруулснаар бүх ажил олгогч болон даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлээ 8.5 хувиар жигд төлөх болсон.

Мөн хуулийн өөрчлөлтөд нийт 49.7 мянган ажил олгогч, 168 мянган даатгуулагч хамрагдаж НДШ-ийг бууруулснаар НДС-д төсвөөс үзүүлэх дэмжлэг нь 2021 онд 94.5 тэрбум, 2022 онд 198.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”, ЗГ-ын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын дагуу тайлангийн хугацаанд 31.8 мянган малчин, 2.6 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч, нийтдээ 34.4 мянган хүн 76.4 тэрбум төгрөгийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлж, шимтгэл нөхөн төлсөн дээрх иргэдээс 11.9 мянган иргэн шинээр тэтгэвэр тогтоолгон, тэдгээрийн тэтгэвэрт 33.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2.2. УИХ-ын Байнгын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийн талаар

НДС-ийн Капитал банкинд байршуулсан хадгаламжийн хөрөнгийг холбогдох яам, агентлагийн төсвийн эрх захирагч нар шийдвэртэй арга хэмжээ авч буцаан авахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу НДҮЗ-өөс 2021 онд өр төлбөр барагдуулах хүрээнд 4 тогтоолыг баталж, хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажилласан байна.

Капитал банкны өр барагдуулахад чиглэсэн “Өр төлбөр барагдуулах тухай” 02, 19, 24 дүгээр тогтоолыг баталж, “Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн сангийн төлбөрт хөрөнгө тооцон авах зөвшөөрөл олгож, холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг НДЕГ-т үүрэг болгон хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

Мөн “НДС-ийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”-ыг баталж, НДС-ийн авлага, өр төлбөрт үл хөдлөх хөрөнгийг авах, эргэлтийн хөрөнгийг ашиглах замаар сангийн авлагыг барагдуулах эрх зүйн орчинг бүрдүүлсний үндсэн дээр 46 объектын 22,156.6 сая төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийг хүлээн авч, эдгээр хөрөнгүүдийг нийгмийн даатгалын байгууллагын нэр дээр бүртгэн авах ажил хийгдэж байна.

Түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байсан аж ахуйн нэгж, иргэнтэй түрээсийн гэрээг шинэчлэн байгуулснаар 2021 онд 22 аж ахуйн нэгж, иргэнээс 25.9 сая төгрөгийг, 2022 онд 24 аж ахуйн нэгж, иргэнээс 38.3 сая төгрөгийг буюу нийт 64.2 сая төгрөгийн түрээсийн орлогыг, орон нутагт байрлалтай 5.2 тэрбум төгрөгийн 12 ширхэг хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулж, 8 хөрөнгийг худалдан борлуулж, 3.1 тэрбум төгрөгийг, 2 орон сууц борлуулсны 484.4 сая төгрөгийг тус тус НДС-д төвлөрүүлсэн байна.

Нийт 4.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 24 ширхэг орон сууцыг ХААН банкны зээлд хамруулж, НДЕГ, ЭМДЕГ-ын хамтран авсан нийт 11.9 тэрбум төгрөгийн 10 ширхэг хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан талаар үйл ажиллагааны тайланд тайлагнан ирүүлсэн байна.

2020 онд НДС-д Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас 826.7 сая, 2021 онд 7,223.3 сая, 2022 онд 200.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, мөн “Өр төлбөр барагдуулж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээ” байгуулан 22,156.6 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, нийтдээ 30,406.6 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, 73,799.9 сая төгрөгийн авлага үлдсэн байна.

НДС-ийн мөнгөн хөрөнгө байршиж буй Үндэсний хөрөнгө оруулалтын банк болон Чингис хаан банк нь Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-т заасан “..... хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх” шаардлагыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн хангахгүй болсон байна.

Үндэсний хөрөнгө оруулалтын банканд 2021 оны эхний байдлаар 5.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсныг өмнөх оны болон энэ оны харилцах дансны хүү 454.0 сая төгрөг, харилцах данснаас 5.82 тэрбум төгрөгийн төлбөрийг 2021 онд барагдуулж, 12.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол Чингис хаан банканд 99.52 тэрбум төгрөгийн үлдэгдэл² байна.

2.3. НДҮЗ-ийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар

НДҮЗ нь 2021 онд 24 тогтоол батлан гаргаснаас “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай”, “Нэрийн дансны 2020 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай”, “Нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” зэрэг нийтээр дагаж мөрдөх 5 тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

2021 онд НДЕГ-т үүрэг, чиглэл болгосон Засгийн газрын тогтоол 13, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 12, НДҮЗ-ийн тогтоол 6, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 3, бусад хамтарсан тушаал 1 буюу нийт 36 тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаагаас 2019 онд 1 шийдвэр, 2020 онд 5, 2021 онд 30 тогтоол шийдвэр гарч, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Үйл ажиллагааны тайланд эдгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг тайлагнаж, 2021 онд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг 98.0 хувийн хэрэгжилттэй буюу “Бүрэн хангалттай” хэрэгжүүлсэн гэж үнэлсэн байна.

д/д	Тогтоол, шийдвэрийн төрөл	Тогтоол, шийдвэрийн тоо	Хэрэгжилтийн хувь
1	Засгийн газрын тогтоол	13	98%
2	Ерөнхий сайдын захирамж	1	100%
3	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	12	98%
4	НДҮЗ-ийн тогтоол	6	98%
5	Сайдын тушаал	3	96%
6	Бусад хамтарсан тушаал	1	100%
Нийт		36	98.3%

НДҮЗ нь 2021 оны үйл ажиллагааны тайландаа нийгмийн даатгалын салбарын хүрээнд үйлчилж буй эрх зүйн актуудыг ангилан хэрэгжилтийг тус бүрд нь тайлагнан ирүүлсэн нь өмнөх жилүүдийн тайлантай харьцуулахад шинэлэг, үр дүнтэй ажил болсон байна.

Мөн тайлант онд НДҮЗ ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 60,000 төгрөгөөр шинэчлэн тогтоож, “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам”, “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилахад баримтлах журам”-ыг тус тус

² 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар

шинэчлэн баталснаар даатгуулагчаас ажилгүйдлийн тэтгэмж авахаар бүрдүүлдэг үйл ажиллагааг цахимжуулж, даатгуулагчийн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлсний зэрэгцээ Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулж, НДС-ийн төсөв боловсруулахад нийгмийн даатгалын бүх шатны байгууллагуудын гүйцэтгэх үүргийг тодорхой болгосон байна.

НДҮЗ-ийн 20, 21 дүгээр тогтоолуудаар Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, НДҮЗ-ийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам”, Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн даатгуулагчдын нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.6 хувиар тогтоож, өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг 2022-2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жил байхаар шийдвэрлэжээ.

Гурав.Байгууллагын үйл ажиллагаандаа системчилсэн үнэлгээ хийсэн эсэх талаар:

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг чиглэл өгсний дагуу НДҮЗ нь 2021 оны үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээг хийж ирүүлсэн байна.

Системчилсэн үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлохдоо байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө, санхүү оновчтой болсон эсэхийг тогтоох шаардлагын үүднээс үнэлгээг хийсэн гэсэн бол үнэлгээний зорилгыг тодорхойлохдоо байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж өөрийн тавьсан зорилгодоо хүрсэн байдлыг тодорхойлоход чиглэнэ гэж тодорхойлжээ.

Системчилсэн үнэлгээний тайлангаас харахад уг үнэлгээ нь тухайн байгууллагын тодорхой чиг үүргийн хэрэгжилтийг задлан шинжилж, хэрэгжүүлж буй чиг үүргийг агуулгын хувьд зөв эсэхийг нягтлан, тэдгээрийг харьцуулах, задлан шинжлэх, шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох, үйл ажиллагааны зардлын үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг системчилсэн үнэлгээний аргачлалаар дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Тухайлбал, хүний нөөцийн хэрэглээний үнэлгээг хийхдээ “салбарын хэмжээнд батлагдсан орон тоогоор 1,436 ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас санхүү, эдийн засгийн мэргэжилтэй 818, хуульч 66, бусад мэргэжлийн 552 албан хаагч байна” гэж тайлагнасан нь хүний нөөцийн хэрэгцээ, хангамжид хийсэн дүгнэлт байхгүй, зайлшгүй шаардлагатай асуудлыг тусгаагүй, хэт ерөнхий мэдээлэл агуулсан байна.

Системчилсэн үнэлгээний шалтгааныг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө санхүү, оновчтой болсон, зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоох гэж тодорхойлсон боловч “Нийгмийн даатгалын байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардалд 27.1 тэрбум төгрөг батлагдсанаас 26.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 0.5 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна. Нийт урсгал зардлын 71.0 хувь буюу 19.0 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын салбарын 1.4 мянган ажилтан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулав.” гэж тайлагнасан нь зардлын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор хийгдсэн үнэлгээний үнэлэлт дүгнэлт өгсөн, дүн шинжилгээ болоогүйг харуулж байна.

Мөн хэрэгжсэн хөтөлбөр болон арга хэмжээнд хэрэгжилтийн үнэлгээ өгөх ретроспектив хэлбэрийг сонгон үнэлгээг хийсэн гэж тодорхойлсон боловч хөтөлбөр, арга хэмжээнд үнэлгээ өгч дүгнэсэн үнэлгээ биш, хуулиар олгосон эрхийн хэрэгжилтийн талаарх тайлан болсон байна. Өөрөөр хэлбэл үнэлгээний хэлбэрийг сонгохдоо тайлангийн агуулгатай нийцүүлэн оновчтой сонгож тогтоож чадаагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь салбарын хүрээнд хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцыг тайландаа тусгаж ирүүлсэн нь өмнөх жилүүдэд Байнгын хороонд ирүүлж байсан тайлантай харьцуулахад үр дүнтэй ажил болсон байна. Улсын Их Хурлын Тамгын газраас НДҮЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээнд үндэслэн дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь 2021 оны үйл ажиллагааны тайлангаа Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн боловч үнэлгээг байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг судалж, ил тод, бодит байдлаар дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй, батлагдсан аргачлалын дагуу хийж ирүүлээгүйгээс системчилсэн үнэлгээ нь тавьсан зорилгоо хангаагүй байна;
2. Байгууллагын үйл ажиллагаанд свот шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлаа тодорхойлж, бий болсон ололттой, давуу талаа ашиглаж сул, эрсдэл үүсгэхүйц асуудлыг нөхөн шийдвэрлэх талаар хувилбар дэвшүүлж, ирэх жилийн төлөвлөгөөнд тусган, биелэлтийг хангаж ажиллахад анхаарах нь зүйтэй. Мөн жилийн үйл ажиллагааны тайландаа гадны шинжээчдийн үнэлгээний багаар хөндлөнгийн үнэлгээний хэлбэрийг сонгож үнэлгээ хийлгэвэл хараат бус бие даасан, илүү бодитой үнэлгээний дүн гарч байгууллагын алдаа дутагдлыг олж харах давуу талтай болохыг зөвлөж байна.
3. Үйл ажиллагааны тайлангаас харахад ололт дэвшилттэй, үр дүнтэй, бүрэн хэрэгжсэн арга хэмжээнүүдийг голчлон тайлагнасан бөгөөд хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй үлдсэн арга хэмжээнүүдийг тайлагнаж ирүүлээгүй байна. Цаашид тогтоол шийдвэрийн болон арга хэмжээний хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг тодруулж тайлагнах, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудын талаар тайлагнах нь дараа оны үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, улмаар шийдвэрлэх гарцыг тодорхойлох боломжтой;
4. Цаашид Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11-т заасан үйл ажиллагааны тайланг ирүүлэхдээ хуулиар олгосон бүрэн эрх, чиг үүргийн дагуу бүрэн гүйцэд, иж бүрэн, тухайн үйл ажиллагааны үр дүнд суурилсан байдлаар тайлагнах, хууль тогтоомжоор олгосон чиг үүрэг болон тогтоол шийдвэрийг хэрэгжүүлснээр гарсан эерэг болон сөрөг үр дүнг тайлагнаж ирүүлэх шаардлагатай байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР